



2030 Усны Нөөцийн Бүлэг Монгол дахь хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүн

Хураангуй

2030 Усны Нөөцийн Бүлэг (2030 УНБ)-ийн Талуудын Оролцооны Платформыг (ТОП) улс орнуудад бий болгож чадавхжуулахад Монгол дахь хөтөлбөрийн туршлагаас суралцах\хуваалцах зорилгоор энэхүү тайланг боловсруулсан. Цаашид усны менежментэд оролцогч талуудын хамтын ажиллагааны энэ механизм бие даан үргэлжлэн ажиллах боломжтой гэж үзэн 2030 Усны Нөөцийн Бүлэг нь Монголд дахь Талуудын Оролцооны Платформын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахаа зогсоож байгаа юм. Үүнтэй холбогдуулан 2030 УНБ-ийн баг болон гол хамтрагч байгууллагуудын төлөөллүүдтэй ярилцлага хийн, тайлан, дүн шинжилгээнүүдийг судалсны үр дүнд хөтөлбөрийн зорилго, баримталдаг арга зүй болон үр дүнгээс энэхүү тайланд тусгасан болно.

Монгол орны усны нөөц, ашиглалтын онцлог

Монгол оронд хур тунадасны тархалт нь тэгш бус, улирлын ялгаа ихтэй байдгаас үүдэн ус ашиглалт, хэрэглээ нь газрын доорх уснаас маш их хамааралтай байдаг. Нөгөөтээгүүр уул уурхай болон хотжилт эрчимтэй хөгжиж байгаа нь өнөөгийн усны нөөц нь ирээдүйд үүсэх усны эрэлт хэрэгцээг хангахгүй байх эрсдэл өндөр бөгөөд энэ нь Монгол улсын усны салбарын тулгамдсан асуудал байсаар ирсэн. Уур амьсгалын өөрчлөлт нь Монгол оронд дэлхийн дунджаас ойролцоогоор 3 дахин илүү (2.25°C) нөлөө үзүүлдэг нь усны нөөцийн асуудлыг илүү хурцдуулж байдаг. Хөгжлийн өндөр эрэлттэй хувилбараар 2030 оны түвшинд Улаанбаатар хотод усны нийт эрэлтийн 43%-ийг, Өмнийн говьд төлөвлөгдөж буй уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүтээн байгуулалттай холбоотой үүсэх усны эрэлтийн 34%-ийг өнөөгийн ашиглах боломжит усны нөөц нь хангалтгүй байж эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүсэх эрсдэлтэй байна.

2030 Усны Нөөцийн Бүлгийн Монгол дахь хөтөлбөр

Монгол улсад усны нөөцийн асуудлуудад оновчтой шийдэл олж менежментийг сайжруулахад хууль, эрх зүй, бодлогын реформын шинжтэй өөрчлөлтүүд сүүлийн 10 жилийн турш хийгдсэн ч хэрэгжилт хангалтгүй байсан байна. Иймээс 2011 онд Монгол улсын Ерөнхийлөгч Дэлхийн Эдийн Засгийн Форумын чуулга уулзалтын үер Дэлхийн Банкны 2030 Усны Нөөцийн Бүлгийг Монгол улсын усны нөөцийн менежментийг талуудын оролцооны платформд суурилан явуулж, эрчимжүүлэх хүсэлт тавьж 2013 онд Монгол дахь хөтөлбөр эхэлсэн.

2030 УНБ нь "Analysis-Convening-Transformation" (ACT) зарчмыг баримталдаг бөгөөд энэ нь (1) Analysis буюу усны нөөцийн менежментийн гол асуудлуудын дүн шинжилгээ, (2) Convening – төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллагууд гэх зэрэг бүх оролцогч талуудыг хамруулсан хэлэлцүүлэг, (3) Transformation буюу төсөл хөтөлбөр, бодлого, журмын хэрэгжилтийг дэмжих замаар өөрчлөлт хийх, хуримтлагдсан усны нөлөөлөл бий болгоход чиглэдэг. 2014 онд Прайс Воутерс Күүперс болон Делтерас зөвлөх компаниудтай хамтран "Монгол Улсын Усны нөөцийн менежментийн асуудалд хийсэн зорилтот шинжилгээ"-ээг хийж Монгол Улсын усны салбарт тулгамдаж буй гол асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх зөвлөмжийг боловсруулсан. Уг зорилтот шинжилгээний зөвлөмжийн дагуу 2030 УНБ усны салбарын асуудлыг түншлэл, хамтын ажиллагааны замаар шийдвэрлэхэд чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн хөтөлбөрийн Удирдах зөвлөл болон ажлын хэсгүүдийг байгуулсан.

АЖЛЫН ХЭСЭГ

1

Усны эрэлтийг бууруулж, ус хангамжийг нэмэгдүүлэх

АЖЛЫН ХЭСЭГ

2

Усны үнэлэмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөшүүргийг боловсронгуй болгох

АЖЛЫН ХЭСЭГ

3

Талуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах



Хөтөлбөрийн үйл ажиллагааны турш 2030 УНБ нь дэмжлэг үзүүлэх, зохицуулах үүргийг гүйцэтгэж гол хамтрагч байгууллагууд нь манлайлж удирдан ажилласаар ирсэн. Үндэсний болон сав газрын түвшинд усны нөөцийн тогтвортой менежментийг эрчимжүүлэх ажлуудын үр дүнг товч дүгнэвэл тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийгдсэн, талуудад шийдлүүдийн хувилбаруудыг танилцуулж хэлэлцүүлсэн, олон улсын сайн туршлагуудаас оновчтой нэвтрүүлсэн, үүний зэрэгцээ чадавх бэхжүүлэх сургалт уулзалтуудыг жил бүр зохион байгуулсан. Гарсан үр дүнг сэдэвчлэн үзүүлбэл:

1. Усны нөөцийн менежментийг сайжруулахад чиглэсэн эрх зүйн орчин, зохицуулах механизмууд

- Усны экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлал, зөвлөмжийг боловсруулсан
- Цэвэрлэсэн ус дахин ашиглах MNS 6734:2018 стандарт боловсруулж батлуулсан
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, холбогдох журмуудын төслийг боловсруулж батлуулсан
- Хот суурины усны үнэ, тарифыг шинэчлэх зөвлөмжийг боловсруулсан
- Төрөөс усны талаар баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн стратегиудыг тодорхойлсон

2. УННМ-д усны үнэ цэнэ, урамшууллыг бий болгоход чиглэсэн ажлуудын үр дүн


- Сайн Дурын Кодексыг 11 уул уурхайн байгууллагууд гарын үсгээ зурж уул уурхайн тогтвортой усны менежмент явуулахад дэмжлэг үзүүлсэн
- “Алтан дусал” шагналын журмыг боловсруулж батлуулсан
- Багшийн ордон дахь хөрсний усыг цэвэршүүлэн дахин ашиглах төсөл хэрэгжүүлж хүлээлгэн өгсөн
- 2030 Усны Нөөцийн Бүлгийн боловсруулсан Улаанбаатар хотын гидроэкономик дүн шинжилгээний зөвлөмжийг үндэслэн хаягдал усыг цэвэрлэн дахин ашиглах зарчмыг хэрэгжүүлэхээр Мянганы Сорилтын Корпорац нь 100 сая орчим ам. долларын санхүүжилтийг шийдсэн
- Газрын доорх усны мониторинг, хяналт-удирдлагын самбар хөгжүүлж хүлээлгэн өгсөн

3. Усны засаглалыг сав газрын түвшинд чадавхжуулах чиглэлээр гарсан үр дүн

- Сав газрын Талуудын Оролцооны Зөвлөл (Т03) байгуулах, ажиллах журмыг боловсруулж батлуулсан
- Үндэсний хэмжээнд СГ Т03-үүдийг байгуулж, шинэчилж, чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулсан

Талуудын оролцооны платформын гүйцэтгэлд өгсөн дүгнэлт

2030 Усны Нөөцийн Бүлгийн Талуудын оролцооны платформын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг KORUMO байгууллага нь өөрсдийн боловсруулсан таван шалгуур үзүүлэлтээр (алсын хараа, зохион байгуулалтын дэмжлэг, дасан зохицох чадвар, засаглал, тогтвортой санхүүжилт) үнэлэн дүгнэсэн. 2030 УНБ нь зохион байгуулалтын дэмжлэг, засаглал, тогтвортой санхүүжилтийн шалгуур үзүүлэлтүүдээр сайн үнэлэгдэж, харин ТОП-ын нээлттэй байдал, хариуцлага хүлээх, оролцооны зарчмыг баримталдаг байсан нь хугацаа шаардаж, ажлын явцыг удаашруулдаг байх төлөвтэй байсан ч нийт үр нөлөө нь эерэг гэж дүгнэгдсэн.



2030 УНБ-ийн Монгол дахь хөтөлбөрөөс бусад улс орны олон талт оролцооны платформыг байгуулахад, сайжруулахад суралцах туршлагаууд

ТУРШЛАГА

1

Тодорхой, уялдаатай, тууштай замаар нэгдмэл алсын хараанд оролцогч талуудыг удирдан чиглүүлэх зарчмыг бүх түвшинд баримтлах. Хөтөлбөр нь

анхдагч зорилго, алсын харааг тууштай баримталж үүнд бусад хамтрагч талуудыг оролцуулж нэгдмэл байдлыг үүсгэсэн.

ТУРШЛАГА

2

Талуудын оролцооны платформыг үр дүнтэй ажиллахад нь дэмжинэ гэдэг нь түүнийг удирдах биш сайн гүйцэтгэгч нь байх. Аливаа олон талт харилцаанд

гуравдагч, хараат бус тал оролцсоноор талуудын итгэлцэл, хамтын ажиллагаа нэмэгддэг. Иймээс, 2030 УНБ нь зөв цагт зөв талуудыг оролцуулж, хоорондын хамтын ажиллагаа үүсгэснээр Талуудын оролцооны платформын чадавхжих нөхцөлүүдийг бүрдүүлсэн.

ТУРШЛАГА

3

Тодорхой байж, "эхэлсэн ажлаа дуусгах". Хөтөлбөр хэрэгжсэнээр гарах үр дүнг, үр нөлөөг тодорхойлсноор цаашид хамтран ажиллах талуудад урам өгч платформын

ирээдүйн үйл ажиллагаа нь тогтвортой болдог. Зарим гарах үр дүн нь төлөвлөлттэй холбоотой бол тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх оролцогч талыг тодорхойлж, чадавхыг бэхжүүлснээр платформын үр нөлөөг нэмэгдүүлнэ.

ТУРШЛАГА

4

Тоон өгөгдөл, мэдээллийг үр дүнтэй ашиглах, мэдээлэл мэдлэг солилцоог эрэмбэлж оновчтой туршлагыг нэвтрүүлэх. Тоон өгөгдлийн аналитик

шийдлүүдийг эрчимтэй нэвтрүүлснээр тулгамдаж буй асуудалд оновчтой шийдэл гаргахад эерэг нөлөө үзүүлдэг. Ингэхдээ, оролцогч талуудад тус аналитик шийдлүүдийг хэрхэн ашиглах, хянах талаар сургалтуудыг явуулах шаардлагатай.

ТУРШЛАГА

5

ТОП-ыг байгуулах, хэрэгжүүлэх үед төлөвлөөгүй, гэнэтийн өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрөх, хариу үйлдэл хийх мэдрэмтгий байх нь илүү боломжуудыг нээж өгсөн. Төлөвлөгөөгүй өөрчлөлтүүд

гарахыг хүлээн зөвшөөрч бэлтгэлтэй байснаар шинэ шийдлийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой болдог.



Дүгнэлт

2013 оноос хойш 2030 Усны Нөөцийн Бүлгийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн ололт, амжилтыг ерөнхийд нь дүгнэвэл: усны салбарын менежментийг зах зээлийн эдийн засгийн харилцаанд бүрэн шилжүүлэх эрх зүй, эдийн засгийн хөшүүрэг, зохицуулалтууд бүрэн бий болсон, бохирдуулагч нь төлөх зарчим хэрэгжиж эхэлсэн, улс орны хөгжлийн томоохон төслүүд, олборлох болон боловсруулах үйлдвэрийн усны эрэлтийг хангах хамгийн үр ашигтай хувилбаруудыг тодорхойлсон, мэдээлэл, судалгаанд тулгуурлан хамгийн оновчтой шийдлийг нь хэлэлцэн тодорхойлж, хэрэгжүүлдэг оролцооны засаглалын хамгийн дэвшилтэт хэлбэрийг бий болгон төлөвшүүлсэн зэрэг Монгол улсын усны салбарын тогтвортой менежментэд бодитой ахиц дэвшил гарчээ.

2030 УНБ-ийн онцлох талууд:

- Талуудын оролцооны платформ болон хамтрагч байгууллагуудын саналыг нэгт эрэмбэлдэг
- Мэдээлэл, судалгаанд үндэслэсэн шийдлүүдийг санал болгохдоо чадварлаг, ажил хэрэгч ханддаг
- Сонирхогч болон оролцогч талуудыг үр дүнтэй хамруулж, шийдвэр гаргалтад оролцуулдаг

Бодит мэдээлэл, судалгаанд үндэслэсэн шийдлүүдийг чадварлаг, мэргэжлийн түвшинд үзүүлж, сонирхогч болон оролцогч талуудыг үргэлж хамруулж, ил тод байдал болон харилцан хариуцлагатай байхыг эрхэмлэдэг нь 2030 УНБ-ийн онцлох зүйл нь байсан. 2030 УНБ нь хууль, эрх зүйн орчин, бодлого, засаглал болон чадавхыг бэхжүүлэх ажлуудын уялдааг маш сайн хангасан. Энэ нь цаашид платформын бие даан орших, оролцооны засаглалыг эрчимжүүлэхэд чухал хүчин зүйл болсон байна. 2030 УНБ-ийн Монгол дахь Талуудын Оролцооны Платформыг цаашид хөгжүүлж, ашиглах нь хамтрагч байгууллагуудын гаргах шийдвэр байх болно.

Усны нөөцийн тогтвортой менежментэд талуудын оролцоог хангахад цогц шийдэл шаардлагатай байдаг учир, бусад улс, оронд талуудын оролцооны платформыг байгуулах, хэрэгжүүлэхэд Монгол дахь хөтөлбөрийн туршлагаас суралцаж ашиглах боломжтой гэж энэхүү тайлангаар дүгнэж байна.

